МЭДЭЭ · 2023 оны 4-р сарын 20

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА 2023 ОНЫ I УЛИРЛЫН БАЙДЛААР 767.448 ЗӨРЧЛИЙН ХЭРЭГТ ХЯНАЛТ ТАВЬЖЭЭ





Прокурорын байгууллагаас 2023 оны I улирлын байдлаар Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах эрх бүхий 31 байгууллагын 7082 зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавьжээ.

- ***Прокурор зөрчлийн хэрэгт үндэслэлгүйгээр шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг зөвтгүүлсэн тохиолдол өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсөв.***

Прокуророос давхардсан тоогоор нийт 767.448 зөрчлийн хэрэгт хяналт тавьж ажилласан нь өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурсан байна. Зөрчлийн хэргийн 72 хувь нь Нийслэлд, 28 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Прокурор зөрчлийн хэрэгт үндэслэлгүйгээр шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгуулахаар 1857, өөрчлөлт оруулахаар 574 дүгнэлт бичиж шүүхээр шийдвэрлүүлэн, зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.

- ***Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг үндэслэлгүйгээр хүлээн авахаас***

татгалзсан эрх бүхий албан тушаалтны 381 шийдвэрийг хүчингүй болгов.

Прокурор зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан эрх бүхий албан тушаалтны 16.179 шийдвэрийг хянаж, үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан 381 шийдвэрийг хүчингүй болгож Зөрчлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан байна.

- ***Прокурор зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 98 шалгалт хийсэн байна.***

Прокурор зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 98 удаагийн шалгалт хийхэд хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй 1654 зөрчил илэрсэн тул холбогдох байгууллагуудад нь 75 прокурорын шаардлага бичиж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан.

- ***Хүүхдийн эрхийг зөрчих, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн хэргийн гаралт өссөн байна.***

2023 оны I улирлын байдлаар Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчил 271 үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 97 хувиар, *Хүний биед халдах зөрчил 17.248 удаа үйлдэгдсэн нь 6.2 хувиар, Олон нийтийн газар зүй бусаар биеэ авч явах зөрчил 2365 удаа үйлдэгдсэн нь 6 хувиар тус тус* буурсан байна.

Харин Хүүхдийн эрхийг зөрчих, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил тус бүр *8 хувиар, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 6.6 хувиар* тус тус өссөн нь хамгийн өндөр хувьтай байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1833